



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

УИХ-ын Төсвийн Байнгын хорооны саналаар хийсэн
гүйцэтгэлийн аудитын тайлан

**ТӨСВӨӨС ОЛГОСОН ХӨРӨНГИЙН ЗАРЦУУЛАЛТЫН ТАЙЛАНГ
НЭГТГЭЖ ГАРГААГҮЙ БАЙНА**



**2010 онд өвөлжилт онц хүндэрсэн аймгуудад улсын
төсвөөс олгосон хөрөнгийн зарцуулалт, хэрэгжилт, үр
дүн**

АГУУЛГА

Тайланг бэлтгэсэн:

ҮАГ-ын Гүйцэтгэлийн
аудитын газар

Захирал

Д.Ганбилэг

Аудитын менежер

Х.Баярмаа

Ахлах аудитор

С.Сэрчхорол

Шинжээч *Д.Баттулга*

2010 оны 10 дугаар сар

**Уг тайланг ҮАГ-ын
вэб сайт-аас үзнэ үү:**

www.mnao.mn

Аудитын тайлантай
холбоотой асуудлаар нэмж
тодруулах, асууж лавлах зүйл
байвал 261885, 263755
дугаарын утас,
323266 дугаарын
факсаар харилцана уу.

ХАЯГ:

Үндэсний аудитын газар
Засгийн газрын 4 дүгээр байр,
Бага тойруу-6, Улаанбаатар-
46
Монгол Улс

Товчилсон үгсийн жагсаалт	2
Аудитын зорилт, хамарсан хүрээ, арга зүй	3
Хөрөнгийн зориулалтыг өөрчилжээ	4
• Оршил	
• ХХААХҮЯ хөрөнгийг Засгийн газрын тогтоолын дагуу хуваарилж, шилжүүлсэн байна	4
• Зарим аймагт төсвөөс олгосон хөрөнгийг зориулалтын дагуу хуваарилж, зарцуулаагүй байна	6
• Төсвөөс олгосон хөрөнгийн зарцуулалтын тайлан гаргаж биелэлтийг тооцоогүй байна	10
• Санал асуулгын дүнгээс үзэхэд зарцуулсан хөрөнгийн бодит үр дүн харагдахгүй байна	10
• Дүгнэлт	12
• Холбогдох байгууллагын санал	13
• Зөвлөмж	16

Товчилсон үг

УИХ	Улсын Их Хурал
МУЗГ	Монгол Улсын Засгийн газар
ХХААХҮЯ	Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам
ХХААХҮС	Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд
ЗДТГ	Засаг даргын Тамгын газар
ХХААЖДҮГ	Хүнс, хөдөө аж ахуй, жижиг дунд үйлдвэрийн газар
ОБХ	Онцгой байдлын хэлтэс
ЭМГ	Эрүүл мэндийн газар
ИТХ	Иргэдийн төлөөлөгчдийн хурал

АУДИТЫН ЗОРИЛТ, ХАМАРСАН ХҮРЭЭ, АРГА ЗҮЙ

Аудитыг Улсын Их Хурлын Төсвийн Байнгын хорооны хүсэлтийг үндэслэн Төрийн аудитын тухай хуулиар тодорхойлсон ҮАГ-ын бүрэн эрхийн хүрээнд хийв.

Аудитын зорилт

2010 онд өвөлжилт онц хүндэрсэн аймгуудад улсын төсвөөс олгосон хөрөнгийн зарцуулалт, хэрэгжилт, үр дүнг шалган дүгнэлт, зөвлөмж боловсруулан холбогдох байгууллага, албан тушаалтанд танилцуулах, олон нийтэд мэдээлэхэд аудитын зорилт чиглэгдэв.

Дээрх зорилтыг хангахын тулд дараахь чиглэлээр аудит хийлээ. Үүнд:

- Олгосон хөрөнгийн санхүүжилт, хуваарилалт зохих ёсоор хийгдсэн эсэх
- Хөрөнгийг үр дүнтэй зарцуулсан эсэх

Хамарсан хүрээ

Аудитад ХХААХҮЯ, зарим аймгийн ЗДТГ, төрийн сан, ХХААЖДҮГ, зарим сум, баг, холбогдох байгууллагуудыг түүвэрчилж хамруулав.

Арга зүй

Аудитыг гүйцэтгэхдээ Төрийн хяналт шалгалтын стандарт, түүнийг хэрэгжүүлэх аргачилсан зөвлөмж, гүйцэтгэлийн аудитын гарын авлага, Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу дараахь арга зүйг ашиглав. Үүнд:

- Хөрөнгө зарцуулалтын талаарх эрхийн актыг судлах;
- ХХААХҮЯ-наас санхүүжүүлсэн хөрөнгийн хуваарилалтыг аймагт олгосон хөрөнгөтэй тулгах;
- Зарим аймгийн ЗДТГ болон ХХААЖДҮГ-т олгосон хөрөнгийн хуваарилалт болон зарцуулалтыг шалган үзэж, дүн шинжилгээ хийх;
- Төсвөөс олгосон хөрөнгийг зардлын зүйл ангиар зарцуулсан эсэхийг түүвэрлэн шалгах;
- Сангийн яам болон холбогдох аймгийн төрийн сан, бусад байгууллагын ажилтнуудтай ярилцлага хийж, тодруулга авах;
- Аймгуудаас санал асуулга (*нэг баг сонгон*) авч нэгтгэх;

Төрийн хяналт шалгалтын стандарт, гүйцэтгэлийн аудитын журамд заасны дагуу аудитын дүн, дүгнэлтэд дэмжлэг болох нотлох зүйлс, холбогдох мэдээ, судалгааг ажлын баримт материалд хавсаргав.

Хөрөнгийн зориулалтыг өөрчилжээ

Оршил

1.1 УИХ-ын 2010 оны 9 дүгээр тогтоолоор өвөлжилтийн байдал хүндэрч байгаатай холбогдуулан авч хэрэгжүүлэх зарим арга хэмжээний хүрээнд 3 760.0 сая төгрөгийг 2010 оны төсвийн тухай хуульд тусгагдсан ХХААХҮС-ын төсвийн багцад багтаан зохицуулалт хийх замаар шийдвэрлэхийг Засгийн газарт зөвшөөрчээ.

1.2 Засгийн газар дээрх шийдвэрийг хэрэгжүүлэхээр 2010 оны 2 дугаар сард 34 дүгээр тогтоол гаргаж, өвөлжилтийн байдал онц хүндэрсэн дараахь аймгуудад зориулан 2 760.0 сая төгрөгийг төсвийн багцаасаа гаргахыг ХХААХҮС-д зөвшөөрснийг зардлын зүйлээр харуулбал,

(сая төгрөгөөр)

№	Аймгийн нэр	Өвс, тэжээлд	Хүн болон малын эм, биобэлдмэлд	Хүнсний болон өргөн хэрэглээний бараанд	Бусад арга хэмжээнд	Нийт зардал
1	Архангай	100.0	50.0	45.0	35.0	230.0
2	Баян-Өлгий	100.0	50.0	45.0	35.0	230.0
3	Баянхонгор	100.0	50.0	45.0	35.0	230.0
4	Говь-Алтай	100.0	50.0	45.0	35.0	230.0
5	Дундговь	100.0	50.0	45.0	35.0	230.0
6	Завхан	100.0	50.0	45.0	35.0	230.0
7	Өвөрхангай	100.0	50.0	45.0	35.0	230.0
8	Өмнөговь	100.0	50.0	45.0	35.0	230.0
9	Төв	100.0	50.0	45.0	35.0	230.0
10	Увс	100.0	50.0	45.0	35.0	230.0
11	Ховд	100.0	50.0	45.0	35.0	230.0
12	Хөвсгөл	100.0	50.0	45.0	35.0	230.0
Нийт дүн		1 200.0	600.0	540.0	420.0	2 760.0

ХХААХҮЯ хөрөнгийг Засгийн газрын тогтоолын дагуу хуваарилж, шилжүүлсэн байна

1.3 Засгийн газраас олгосон хөрөнгийг зориулалтын дагуу зарцуулж, гүйцэтгэлийн тайланг холбогдох баримтын хамт 2010 оны 5 дугаар сард багтаан Сангийн яам болон ХХААХҮЯ-д ирүүлэхийг холбогдох аймгийн Засаг дарга нарт даалгасан байна.

1.4 Засгийн газрын 2010 оны 3 дугаар сарын 3-ны өдрийн 52, 10-ны өдрийн 52 дугаар тогтоолуудаар зарим аймгуудад малын сэг зэмийг устгах, ариутгал, халдваргүйтгэл хийх болон ажлын хэсгийн томилолтод 290.0 сая, ОХУ-аас буцалтгүй тусламжаар ирүүлсэн буудайг тээвэрлэхэд зориулж зарим аймагт 131.0 сая, буудайг төмөр замаар тээвэрлэх болон ашиглалтын зардалд 126.0 сая, ачиж буулгахад 51.0 сая, буудайнд лабораторийн шинжилгээ хийхэд 3.0 сая, нийт 311.0 сая төгрөгийг ХХААХҮС-ын багцаас гаргахыг зөвшөөрсний дагуу ХХААХҮС 2010 оны 3 дугаар сарын 31-ний өдрийн А/64 дугаар тушаал гаргаж хуваарилсан байна.

1.5 ХХААХҮС-ын 2010 оны 2 дугаар сарын 11-ний өдрийн 32 дугаар тушаалын дагуу өвөлжилт хүндэрсэн 12 аймгийн төрийн сан дахь ХХААЖДҮГ-ын харилцах дансад 2 760.0 сая төгрөгийг шилжүүлжээ.

1.6 ОХУ-аас тусламжаар ирсэн буудайг тээвэрлэхэд 113.5 сая, тэжээлийн буудайг тээвэрлэх, ачилт буулгалтын зардалд зориулж 118.4 сая төгрөгийг тус тус дараахь 8 аймагт шилжүүлсэн байна.

(мянган төгрөгөөр)

№	Аймаг	Тээврийн зардал	Ачилт, буулгалтын зардал	Нийт зардал
1	Сэлэнгэ	6000.0	3000.0	9000.0
2	Дархан-Уул	2500.0	2500.0	5000.0
3	Булган	15750.0	-	15750.0
4	Орхон	3000.0	7500.0	10500.0
5	Говьсүмбэр	5000.0	2000.0	7000.0
6	Хэнтий	16569.0	750.0	17319.0
7	Дорноговь	10000.0	5000.0	15000.0
8	Сүхбаатар	38850.0	-	38850.0
	Нийт дүн	97669.0	20750.0	118419.0

1.7 Засгийн газрын 57 дугаар тогтоол, ХХААХҮС-ын А\64 дүгээр тушаалын дагуу 311.0 сая төгрөг зарцуулахаас 231.9 сая төгрөгийн гүйцэтгэл гарсан боловч төмөр замд олгосон хөрөнгийн зарцуулалтын тооцоог эцэслэж баталгаажуулаагүй байлаа.

1.8 ХХААХҮС-ын 2010 оны 3 дугаар сарын 31-ний өдрийн 63 дугаар тушаалаар малын сэг, зэмийг устгахад шаардагдах ариутгал халдваргүйжүүлэлтийн бодис, багаж хэрэгсэл худалдан авахад 200.0 сая, тээвэр, шатахуунд 84.0 сая, ажлын хэсгийн томилолтод 6.0 сая, нийт 290.0 сая төгрөг зарцуулах шийдвэр гарчээ.

1.9 Энэ шийдвэрийн үндсэн дээр ХХААХҮЯ-наас малын сэг, зэмийг устгахад шаардагдах ариутгал, халдваргүйжүүлэлтийн бодис, багаж хэрэгсэл худалдан авахад 164.7 сая, ажлын хэсгийн томилолтод 6.0 сая, тээвэр, шатахуунд 9 аймагт 84.0 сая, нийт 254.7 сая төгрөг шилжүүлжээ.

1.10 Мал эмнэлэг, үржлийн газар малын сэг, зэм устгахад шаардагдах ариутгал, халдваргүйжүүлэлтийн бодис худалдан авахдаа ТБОНӨХБАҮХАТХ-ийн дагуу нээлттэй тендер зарлаж хуурай бэлдмэлийг 46.8 сая, шингэн бэлдмэлийг 117.9 сая төгрөгөөр бэлтгэсэн байна.

1.11 ХХААХҮС-ын 63 дугаар тушаалаар аймаг, орон нутагт шаардагдах ариутгал, халдваргүйжүүлэлтийн бодис олгох хуваарь гарсан боловч Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг Мал эмнэлэг, үржлийн газар зарим аймгуудаас санал авч дахин хуваарилсан байна.

1.12 Мал эмнэлэг, үржлийн газар ариутгалын бодисыг тараахдаа гүйцэтгэлийн тайлан гаргуулах, хяналт тавих үүргээ орхигдуулсан байна.

1.13 Ариутгалын бодис хуваарилсан нэгдсэн тайлангаас харахад 29.8 сая төгрөгийн ариутгалын бодисыг зарцуулаагүй байхад зарцуулснаар тайлагнажээ.

Тухайлбал,

- + Говьсүмбэр аймагт 2.8 сая төгрөгийн ариутгалын бодис зарцуулаагүй;
- + Орхон аймагт 4.7 сая төгрөгийн үнэ бүхий “Повидон иод”-ыг орлогод авч, тайлан гаргаагүй;
- + Баянхонгор аймаг 200 литр “Повидон иод”, 140 кг хлорын шохой;
- + Булган аймаг 2520 литр “Повидон иод”, 1000 кг хлорын шохой;
- + Дархан-Уул аймаг 500 литр “Повидон иод”;
- + Хэнтий аймаг 900 литр “Повидон иод”-ыг тус тус зарцуулаагүй байлаа

1.14 УИХ, Засгийн газрын тогтоолын дагуу өвөлжилт онц хүндэрсэн аймгуудад төсвөөс зарцуулах 3 760.0 сая төгрөгөөс 3 246.6 сая төгрөг зарцуулж, 9 дүгээр сард Сүхбаатар, Дорнод аймагт гарсан шүлхий өвчний халдваргүйжүүлэлтэд зориулан ариутгалын тусгай зориулалтын хувцас,багаж, хэрэгсэл авахад 29.2 сая, буудайд лабораторийн шинжилгээ хийхэд 3.0 сая төгрөг нэмж зарцуулснаар 9 дүгээр сарын 15-ны байдлаар 481.2 сая төгрөг үлдсэн байна.

1.15 ХХААХҮЯ нь ОБЕГ-тай хамтран ажлын хэсэг гарган өвөлжилт онц хүндэрсэн аймгуудад олгосон хөрөнгийн зарцуулалт, хэрэгжилтийн явцад хяналт шалгалт хийсний зэрэгцээ үр дүнгийн талаар судалгаа, шинжилгээний ажил зохион байгуулж ажиллажээ.

Зарим аймагт төсвөөс олгосон хөрөнгийг зориулалтын дагуу хуваарилж, зарцуулаагүй байна

1.16 Засгийн газрын тогтоол, ХХААХҮС-ын тушаалаар өвөлжилт онц хүндэрсэн аймгуудад олгосон хөрөнгийн гүйцэтгэлийг харуулбал:

(сая төгрөгөөр)

№	Аймгийн нэр	Өвс, тэжээлд	Хүн болон малын эм, биобэлдмэлд	Хүнсний болон өргөн хэрэглээний бараанд	Бусад арга хэмжээнд	Нийт зардал	Зөрүү
1	Архангай	100.0	50.0	45.0	35.0	230.0	
2	Баян-Өлгий	110.1	33.9	51.6	34.3	229.9	
3	Баянхонгор	150.8	29.7	20.6	28.8	229.9	
4	Говь-Алтай	113.4	45.4	23.7	47.0	229.5	
5	Дундговь	99.9	49.9	44.9	32.8	227.5	2.5
6	Завхан	30.8	15.0	13.9	170.3	230.0	
7	Өвөрхангай	100.0	49.9	45.0	35.0	230.0	
8	Өмнөговь	30.0	35.7	130.7	33.6	230.0	
9	Төв	72.0	52.1	-	105.4	229.5	
10	Увс	81.0	47.1	45.0	56.9	230.0	
11	Ховд	89.9	18.8	10.1	111.2	230.0	
12	Хөвсгөл	97.9	50.0	45.0	34.9	227.9	2.1
Нийт дүн		1075.8	477.5	475.5	725.2	2 754.2	4.6

1.17 Дээрх хүснэгтээс үзэхэд өвөлжилт онц хүндэрсэн аймгуудад төсвөөс олгосон хөрөнгийг зарим аймгууд зардал хооронд нь гүйлгэсэн ба зориулалт бусаар зарцуулсан байлаа.

1.18 Засгийн газрын тогтоолоор өвс, тэжээлд зарцуулах хөрөнгийг 124.2 сая, хүн болон малын эм, биобэлдмэлд зарцуулах хөрөнгийг 122.5 сая, хүнсний болон өргөн хэрэглээний бараанд зарцуулах хөрөнгийг 64.5 сая төгрөгөөр тус тус дутуу буюу өөр зардалд гүйлгэн зарцуулсан бөгөөд бусад арга хэмжээнд зарцуулах хөрөнгийг 305.2 сая төгрөгөөр хэтрүүлжээ.

1.19 Ялангуяа Төв, Ховд, Завхан аймаг бусад арга хэмжээний зардалд батлагдсан хөрөнгийг 70.4-135.3 сая төгрөгөөр хэтрүүлэн зарцуулсан байна.

1.20 Зарим аймгийн Засаг дарга нар ЗГ-ын тогтоол, ХХААХҮС-ын баталсан зардлын ангиллыг баримтлаагүй, шаардлага хангаагүй бараа, материал нийлүүлсэн, харилцан адилгүй хуваарилсан тохиолдол илэрлээ. Тухайлбал,

1.21 **Архангай аймаг** төсвөөс олгосон хөрөнгийг зориулалтын дагуу хуваарилсан боловч зарим сумдын удирдлага мэдээгүй байхад хөрөнгийг хэнд олгосон нь тодорхойгүй, өргөн хэрэглээний зарим бараа материалыг тэнцвэргүй байдлаар олгосон (*өвөлжилтийн байдал ерөнхийдөө ойролцоо байхад зарим багийн 4 өрхийн дунд 25 кг-ын нэг шуудай гурил олгосон бол зарим багт нэг өрхөд 25 кг гурил олгосон, Ихтамир суманд 29 гутал, 48 багц эмийн сан хэнд очсон нь тодорхойгүй*) байлаа.

1.22 Сумдын нийт өрхийн 32.4-91.2 хувь нь өвөлжилт ихээр хүндэрсэн байдалтай байхад нэг өрхөд ногдох тэжээлийн хэмжээ харилцан адилгүй 5.9-45.0 кг байна. (*Эрдэнэмандал суманд 5.9 кг, Хотонт суманд 45.0 кг*)

1.23 **Баянхонгор аймаг** төсвийн хөрөнгийг батлагдсан хуваарийг харгалзалгүй зардал хооронд гүйлгэн зарцуулсан байна. Өвс, тэжээл худалдан авахад 164.0 сая, хүн болон малын эм биобэлдмэл худалдан авахад 31.0 сая, малын сэг, зэм устгахад 35.0 сая төгрөг хуваарилж, хүнс болон өргөн хэрэглээний бараа худалдан авахад хөрөнгө зарцуулаагүй байлаа.

- + Аймгийн засаг даргын 2010 оны 4 дүгээр сарын 2-ны өдрийн 132 дугаар захирамжаар нэг боодол өвсийг 2500 төгрөгөөр үнэлэн малчдаас төлүүлэхээр шийдвэрлэсэн;
- + 2.7 сая төгрөгийн эм биобэлдмэлийг малчдад олгоггүйгээр ХХААЖДҮГ-ын нөөцөд авсан;
- + 27.8 сая төгрөгийн эм биобэлдмэлийг орлогод аваагүй байна.

1.24 **Говь-Алтай аймаг** төсвийн хөрөнгийн бусад арга хэмжээний зардлаас Баян-Уул, Эрдэнэ сум 30.0 сая төгрөгөөр суудлын автомашин худалдан авсан байна.

1.25 **Дундговь аймаг** төсвийн хөрөнгийг зориулалтын дагуу хуваарилж зарцуулсан боловч малчдаас тээврийн хөлс авсан тохиолдол гарчээ. Тухайлбал,

- + Хулд суманд будаа, гурил олгохдоо тээврийн зардлыг ХХААЖДҮГ-аас шилжүүлсэн байхад 440.0 мянган төгрөгийг малчдаар төлүүлсэн;
- + Говь-Угтаал, Баянжаргалан, Өндөр шил, Луус, Өлзийт, Хулд, Сайхан-Овоо, Сайнцагаан зэрэг сумдад ачуулсан 22.2 сая төгрөгийн үнэ бүхий 47.3 тн гурилыг хүлээн авсан хүний гарын үсээгүй, анхан шатны баримт материал дутуу байлаа.

1.26 **Завхан аймаг** төсвийн хөрөнгийн зориулалтыг өөрчлөн 100.2 сая төгрөгийг сумдад бэлнээр, 50.0 сая төгрөгийг орон нутгийн чанартай замын зорчих хэсгийн цасыг цэвэрлэхэд, 30.8 сая төгрөгийг өвс тэжээлд, 5.0 сая төгрөгийг аймгийн ЭМГ-т эм авахад, 10.0 сая төгрөгийг малын эм биобэлдмэл авахад зориулан ХХААЖДҮГ-т, 13.8 сая төгрөгийг гурил авахад, 10.0 сая төгрөгийг Аймгийн ОБХ-т гамшгийн нөөц бүрдүүлэхэд, 10.0 сая төгрөгийг аймгийн ИТХ-д сумдад төлөөлөгч ажиллуулах, эрүүл мэндийн үйлчилгээг иргэдэд хүргүүлэхээр тус тус хуваарилсан бөгөөд зарцуулалтыг шалгахад дараах зөрчил дутагдал илэрсэн байна.

- + Аймгийн ОБХ-ийн даргын автомашины сэлбэгэнд 5.6 сая;
- + Отгон сумын засаг дарга УБ хотоос таримал ургамлын үр болон агрегат ачиж ирсэн тээврийн хөлсөнд 1.5 сая;
- + Завханмандал сум нүүрс худалдан авахад 1.2 сая;
- + Их-Уул сумын засаг дарга гэрээт ажилчны цалин, шатахуунд 1.5 сая;
- + Улиастай сумын засаг дарга малчдад олгох 0.6 сая төгрөгийг гурилыг суваг шуудуу гаргасан хүмүүст олгосон, 0.7 сая төгрөгийг нүүрс худалдан авахад тус тус зориулалт бусаар зарцуулсан байна.

1.27 **Өвөрхангай аймаг** Өвс, тэжээлд зарцуулах 100.0 сая төгрөгөөс 33.3 сая төгрөгийг хөх буудайн тээврийн зардалд, 16.6 сая төгрөгийг 374.1 тн хивэг тээвэрлэсэн тээврийн зардалд зарцуулсан байна.

1.28 Төсвийн хөрөнгийг өвөлжилт онц хүндэрч гамшгийн зэрэгт хүрсэн Баянгол, Сант, Баян-Өндөр, Төгрөг зэрэг сумдад зориулалтын дагуу өвс, тэжээл түлхүү хуваарилж зарцуулаагүй бөгөөд дараахь зөрчил дутагдал илэрлээ.

- + ОБХ-т шилжүүлсэн хөрөнгөөс автомашины сэлбэгт 2.0 сая төгрөг зарцуулсан;
- + Малчдад олгох 50.0 тн нүүрс хэнд олгосон нь тодорхойгүй;
- + 30.6 тн гурил бэлтгэхдээ тухайн үеийн зах зээлийн ханшаас илүү үнээр бэлтгэсэн;
- + Малчдад үнэгүй олгох 0.6 сая төгрөгийг эмийг худалдан борлуулсан;
- + 0.7 сая төгрөгийг сургалтын зардал болон эмчийн халад, цэргийн үүргэвч худалдан авахад зарцуулсан байна.

1.29 **Өмнөговь аймаг** Өвс тэжээлд 30.0 сая, хүн болон малын эм биобэлдмэлд 35.7 сая, хүнс болон өргөн хэрэглээний бараанд 130.7 сая, бусад арга хэмжээнд 33.6 сая төгрөгийг зарцуулахаар шийдвэрлэсэн байна. Өвс тэжээлд хуваарилсан хөрөнгөөс 15 сум бүрт 2.0 сая, нийт 30.0 сая төгрөгийг төлийн тэжээлд зориулан олгосон байна.

1.30 **Төв аймаг** Өвс, тэжээлийн зардалд ногдох хөрөнгийг 28.0 сая төгрөгөөр дутуу, харин бусад зардлыг 70.2 сая төгрөгөөр илүү зарцуулсан төдийгүй дараахь зөрчил илэрлээ. Үүнд:

- ✚ *Өвөлжилтийн байдал хүндэрсэн цас зудтай суманд бус бүх сумдад 19.0 сая төгрөгийн шатахууныг хавтгайруулан олгосон;*
- ✚ *8.3 тн тэжээлийг 730 мянган төгрөгөөр, 18.6 тн өвсийг 1.2 сая төгрөгөөр худалдан борлуулсан;*
- ✚ *Баян-Өнжүүл сум нэг шуудай тэжээлийн буудайг 2000, нэг боодол сүрлийг 1000 төгрөгөөр үнэлж худалдсан;*
- ✚ *Аймгийн Засаг даргын 2010 оны 8 дугаар сарын 10-ны өдрийн 421 дүгээр захирамжаар зарцуулаагүй үлдсэн хөрөнгөөс 48.7 сая төгрөгийг аймгийн мал хамгаалах санд шилжүүлж, 4.0 сая төгрөгийг ХХААЖДҮГ-т үлдээжээ.*

1.31 **Ховд аймаг** төсвийн хөрөнгийг батлагдсан зориулалтын дагуу хуваарилж зарцуулаагүй байна. Өвс, тэжээлд зарцуулах хөрөнгөөс 10.1 сая, хүн болон малын эм биобэлдмэлд батлагдсан хөрөнгөөс 31.2 сая, хүнсний болон өргөн хэрэглээний бараанд зарцуулагдах хөрөнгөөс 34.9 сая төгрөг дутуу зарцуулж, харин бусад арга хэмжээнд 76.2 сая төгрөг нэмж зарцуулахаар шийдвэрлэсэн байна.

1.32 Үүнээс гадна 33.1 хувийг зориулалт бусаар зарцуулсан байна. Тухайлбал,

- ✚ *Аймаг 28.5 сая төгрөгөөр шалгүй 30 гэр бэлтгэснээс 16 гэр тараагдаагүй;*
- ✚ *Үенч сум улсын төсвөөс олгосон хөрөнгөөс багийн хөгжлийн сан байгуулах зорилгоор 7.5 сая төгрөгийг төсвийн гадуур дансанд шилжүүлсэн;*
- ✚ *Усан цахилгаан станцад 2.5 сая төгрөг зээлдүүлсэн боловч, эргүүлж төлүүлж аваагүй, авлагаар тусгаагүй байна.*

1.33 **Хөвсгөл аймаг** 230.0 сая төгрөгийг аймгийн мал хамгаалах сангийн дансад нэг сарын хугацаанд байршуулж, 20.0 сая төгрөгийг байрны дулааны зардалд түр хугацаагаар зарцуулснаар тусламжийг оройтож олгосон байна. Өвс, тэжээлд хуваарилсан 100.0 сая төгрөгөөс 32.6 сая төгрөгийг будааны тээврийн зардалд зарцуулсан болон дараахь зөрчил дутагдал илэрсэн байна.

- ✚ *Малчдад тараасан өвс, сүрэл харлаж, хөгцөрсөн;*
- ✚ *Тэжээл нь цементтэй холилдсон;*
- ✚ *Шуудайтай тэжээл жиндээ хүрэхгүй;*
- ✚ *Тэжээлийн будаа хугацаа оройтож ирсэн (7 дугаар сард өгсөн), зарим хэсэг одоо хүртэл тараагдаагүй;*
- ✚ *Тусламжаар бэлтгэсэн 90.0 тн гурилыг тараахдаа аймгийн төвөөс суманд хүргэсэн тээврийн зардал гэж өрх бүрээс 500-1000 төгрөг авсан, уг гурил хүнсэнд хэрэглэх боломжгүй тул төл мал тэжээхэд хэрэглэжээ.*

1.34 **Үес аймаг** төсвийн хөрөнгийн бусад зардалд батлагдсан хөрөнгийг 21.8 сая төгрөгөөр хэтрүүлж зарцуулсан байна. Түүнчлэн,

- ✚ Малчдад олгосон өвс, тэжээл, тусламжийн барааг хүлээн авсан хүний гарын үсгийг хуурамчаар үйлдэж баримт бүрдүүлсэн тохиолдол гарсан (Түргэн сумын Рашаант багийн малчин Г.Ганбаатарт 50 кг хорголжин тэжээл, 2 боодол өвс, 10000 төгрөг бэлнээр тарааснаар хуурамч баримт бүрдүүлсэн);
- ✚ Өвс тэжээлийг малчдад зарсан (50 кг хорголжин тэжээлийг 7500, улаан хивгийг 3500, 2 боодол өвсийг 2600 төгрөгөөр тооцож зарсан);
- ✚ “Гурил-Увс” ХК-иас авсан 45.7 сая төгрөгийн гурил хүнсний хэрэгцээнд хэрэглэх боломжгүй;
- ✚ Аймгийн төвийн хөлдсөн шугам сүлжээг засахад 7.5 сая, эрчим хүчний шугам засварлахад 3.2 сая төгрөгийг зориулалт бусаар тус тус зарцуулжээ.

1.35 Аудитын дүнгээс үзэхэд аймгийн Засаг дарга нар олгосон хөрөнгийг зориулалтын дагуу хуваарилах, зарцуулах асуудлыг оновчтой зохион байгуулах, хэрэгжилтэд хяналт тавихад хангалтгүй ажилласан байна.

Төсвөөс олгосон хөрөнгийн зарцуулалтын тайлан гаргаж, биелэлтийг тооцоогүй байна

1.36 Монгол Улсын Засгийн газрын 32 дугаар тогтоолын¹ 3 дахь заалтыг зарим аймгийн Засаг дарга нар биелүүлээгүй байна.

1.37 Өөрөөр хэлбэл, өвөлжилт онц хүндэрсэнтэй холбогдуулан улсын төсвөөс олгосон хөрөнгийн зарцуулалт, гүйцэтгэлийн нэгдсэн тайланг Увс, Төв аймгаас бусад аймаг бүрэн нэгтгэж ирүүлээгүй байна.


1.38 УИХ, Засгийн газрын тогтоолоор өвөлжилт хүндэрсэнтэй холбогдуулан төсвөөс олгосон хөрөнгийн зарцуулалтын тайланг баг, сум, аймгийн хэмжээнд нэгтгэх асуудал орхигдсон, одоо болтол нэгдсэн тайлан гараагүй, үр дүнг тооцоогүй байна. Тухайлбал,

- ✚ Архангай аймаг бараа, материалыг аймгийн Иргэдийн хурлын төлөөлөгчөөр дамжуулан тараасан тул баг, сумын хэмжээнд тайлан мэдээг ирүүлээгүй;
- ✚ Баян-Өлгий аймагт эм, биобэлдмэлийн тайланг нэгтгэж гаргаагүй;
- ✚ Баянхонгор аймагт үнэгүй тараасан малын эм биобэлдмэлийн зарцуулалтын тайланг 28 аж ахуйн нэгж дутуу, 14 аж ахуйн нэгж тайланг ирүүлээгүй;
- ✚ Завхан аймгийн Булнай, Сантмаргац, Нөмрөг, Тэлмэн, Сонгино, Идэр сум зарцуулалтын тайланг ирүүлээгүй;
- ✚ Өвөрхангай, Өмнөговь, Ховд, Хөвсгөл аймаг зарцуулсан хөрөнгийн гүйцэтгэлийн тайланг нэгтгэж тайлагнаагүй;
- ✚ Төв аймгийн 19 сум малчдад олгосон эмийн зарцуулалтын тайланг гаргаж ирүүлээгүй;
- ✚ Хөвсгөл аймаг 16.6 сая төгрөгийг эмнэлгийн тусламж үзүүлсэн гэж тайлагнасан ч гүйцэтгэлээр 2.8 сая төгрөг зарцуулаагүй үлдсэн байлаа.

Санал асуулгын дүнгээс үзэхэд зарцуулсан хөрөнгийн бодит үр дүн харагдахгүй байна.

¹ Монгол Улсын Засгийн газрын 2010 оны 2 дугаар сарын 10-ны өдрийн 34 дүгээр тогтоолын 3-т “Олгосон хөрөнгийг тогтоолын хавсралтад заасан зориулалтын дагуу зарцуулан, гүйцэтгэлийн тайланг гаргаж холбогдох баримтын хамт 2010 оны 5 дугаар сард багтаан Сангийн яам болон Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яаманд хүргүүлэхийг холбогдох аймгийн Засаг дарга нарт даалгасгай”

1.39 Өвөлжилт хүндэрсэнтэй холбогдуулан төсвөөс олгосон хөрөнгийн зарцуулалтад хийсэн аудитаар Баян-Өлгий, Өмнөговь, Дундговь аймаг тусламж малчдад үр дүнтэй хүрсэн гэж дүгнэсэн бол бусад аймгийн хувьд үр дүн муутай арга хэмжээ боллоо гэжээ.



1.40 Өвөлжилт хүндэрсэнтэй холбогдуулан 12 аймагт олгосон төсвийн хөрөнгийн зарцуулалт, хэрэгжилтэд аудит хийх явцад 600 гаруй малчнаас санал асуулга авч дүнг нэгтгэлээ. Эндээс зарим асуулгыг графикаар харуулбал, санал асуулгад оролцогсдын 47.9 хувь төсвийн хөрөнгөөр бэлтгэсэн зүйл хэрэг болох хэмжээнд өгөгдөөгүй гэж хариулсан байна.

1.41 Өвс, тэжээл, бараа материалыг хэр оновчтой хуваарилсан бэ? гэсэн асуултад санал асуулгад оролцогсдын 47.9 хувь эзнээ олоогүй, ирсэн бараа, материалын үнэ ямар байсан талаархи асуултад 26.8 хувь нь үнэтэй байсан, олгосон хөрөнгө үр дүнтэй байсан эсэх талаархи асуултад 19.7 хувь хангалтгүй, дэмжлэг авснаар хохирол багассан уу? асуултад 53.2 хувь нь нөлөөлөөгүй гэж тус тус хариулсан байна.

1.42 Өвөлжилт онц хүндэрсэн аймгуудад улсын төсвөөс олгосон хөрөнгийн талаар авсан санал асуулгыг нэгтгэсэн дүгнэлтээс үзэхэд хөрөнгийг зүй зохистой зарцуулсан, дэмжлэг авснаар бодит үр дүн гарч хохирол багассан эсэхэд малчид эргэлзээтэй байна.

1.43 Аудитаар 43.8 сая төгрөгийн төлбөрийн акт тогтоогдож, 126.6 сая төгрөгийн зөрчлийг арилгуулахаар албан шаардлага өгсөн байна. (Хавсралт № 1-ээр харуулав) Аудитын явцад 20.0 сая төгрөгийн төлбөр барагджээ.

ДҮГНЭЛТ

Аудитын явцад цуглуулсан нотлох зүйлс, аудитын дүнд үндэслэн дараахь дүгнэлт хийж байна. Үүнд:

- ✚ Өвөлжилт хүндэрсэн зарим аймгууд Засгийн газрын тогтоолоор олгосон хөрөнгийг зориулалтын дагуу хуваарилж, зарцуулаагүй байна.
- ✚ Улсын төсвөөс олгосон хөрөнгийн гүйцэтгэлийг 2 аймгаас бусад 10 аймаг нэгтгэж, тайлагнаагүй байна.
- ✚ Зарим аймгийн удирдлагад жил бүрийн өвөл гарч болох хүндрэлийг урьдчилан тооцох, түүнд бэлтгэлтэй хандах арга барил дутагдалтай байгаагийн зэрэгцээ учирч буй эрсдэлийг үнэлэн тооцож хөрөнгийг хуваарилах, хохирол багатайгаар давах талаар бэлтгэл зохион байгуулалтын дадлага, чадвар үгүйлэгдэж байна.
- ✚ Өвөлжилт онц хүндэрсэн аймгуудад хөрөнгө олгосноор малын хорогдол буурсан, хохирол багассан эсэхийг бодитойгоор тооцох боломжгүй байна.

Холбогдох байгууллагын санал



МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ
АУДИТОР Ч.РАДНАА ТАНАА

МОНГОЛ УЛСЫН ХҮНС, ХӨДӨӨ АЖ АХУЙ, ХӨНГӨН ҮЙЛДВЭРИЙН ЯАМ

13381 Улаанбаатар хот, Баянзүрх дүүрэг,
Энхтайваны өргөн чөлөө 16а, Засгийн газрын IX байр,
Утас: 26-22-71, Факс: (976-11) 45-25-54,
E-mail: mofa@mofa.gov.mn; http://www.mofa.gov.mn

2010.10.07 № 1/3095
танай _____-ны № _____-т

Тайланд санал өгөх тухай

УИХ-ын төсвийн Байнгын хорооны саналаар 2009-2010 оны зудын нөхцөл байдалтай холбогдуулан аймгуудад Улсын төсвөөс олгосон 3760.0 сая төгрөгийн зарцуулалт, хэрэгжилт, үр дүнд хийсэн аудитын тайлан дүгнэлттэй танилцлаа.

Тайланд дурьдсан баримт материал, дүгнэлт, зөвлөмж нь хууль, тогтоомжийн дагуу хийгдсэн гэж үзэж байна.


Гэвч тайлангийн 1.12-т дурьдсан дүгнэлтийн хувьд ХХААХУ-ийн сайдын тушаалаар аймгуудад хувиарлах ариутгалын бодисыг Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг Мал эмнэлэг, үржлийн газар нь олгохдоо тухайн үед өвөлжилтийн байдал хүндэрсэнээс хорогдсон олон зуун малын сэг зэмийг устгаж, ариутгал хийх шаардлагатай байгаа талаар тушаалд заагдаагүй зарим аймгуудаас ирүүлсэн санал, хүсэлтийг үндэслэсэн байна.

Иймд энэ асуудлыг эргэж харна уу

Жич: Тухайн үед аймгуудаас ирүүлсэн санал, хүсэлтийн хуулбарыг хавсаргав.

Тайлбар 1-ийг
үзнэ үү.

ТӨРИЙН НАРИЙН
БИЧГИЙН ДАРГА



Т.ГАНТУЛГА

Төмөр хэргийн хууль-2010.01

0804235

Холбогдох байгууллагын санал

Аймаг, нийслэлийн Мал эмнэлгийн албадаас ирүүлсэн
ариутгал, халдваргүйжүүлэлтийн бодисын захиалга

2010.05.20

№	Аймгийн нэр	Захиалга		Захиалга ирүүлсэн огноо
		Хлорын шохой /тн /	Повидон Иод/ г/	
1.	Баянхонгор	1.0	1000	20.5.2010
2.	Говь-Алтай	3.0	1000	12.5.2010
3.	Увс	4.0	1000	12.5.2010
4.	Говьсүмбэр	1.0	1000	13.5.2010
5.	Сүхбаатар	3.0	1000	13.5.2010
6.	Дорноговь	2.0	0	13.05.2010
7.	Хэнтий	10.0	5000	12.5.2010
8.	Завхан	5.8	2500	12.05.2010
9.	Дархан-Уул	0	500.0	12.05.2010
10.	Сэлэнгэ	0	1500	12.05.2010
11.	Орхон	2.5	1000	12.05.2010
12.	Өмнөговь	9.0	300.0	12.2010.2010
13.	Булган	3.0	2500	12.05.2010
14.	Төв аймаг	4.0	3000	12.05.2010
15.	Хөвсгөл	1.0	100.0	12.05.2010
	Нийт дүн	49.3	20400	

Нэгтгэсэн: Мэргэжилтэн

Ш. Мөнхтөр

Ш. Мөнхтөр

Тайлбар:

Тайлбар 1

Ирүүлсэн саналыг үндэслэн тайлбарыг хүлээн авлаа.

ЗӨВЛӨМЖ

Аудитын дүн, дүгнэлтэд үндэслэн дараахь арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг дор дурдсан албан тушаалтанд зөвлөж байна. Үүнд:

Нэг. Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд Т.Бадамжунайд:

- ✚ УИХ-ын болон Засгийн газрын тогтоолоор өвөлжилт онц хүндэрсэн аймгуудад улсын төсвөөс олгосон хөрөнгийн зарцуулалтын тайланг гаргуулан авч нэгтгэх, үр дүнг тооцож тайлагнах;
- ✚ Өвөлжилт онц хүндэрснээс учирч буй эрсдэлийг үнэлэх, авч хэрэгжүүлж буй арга хэмжээний үр дүнг тооцох талаар орон нутгийн удирдлагуудад тодорхой чиглэл өгч, хэрэгжилтэд хяналт тавьж ажиллах;
- ✚ Засгийн газрын тогтоолоор олгосон хөрөнгийг зориулалт бусаар зарцуулсан, мэдээ, тайланг хугацаанд нь ирүүлээгүй аймгийн удирдлага, албан тушаалтанд хариуцлага тооцох тухай санал боловсруулж шийдвэрлүүлэх арга хэмжээ авах;

Өвөлжилт онц хүндэрсэн аймгуудад төсвөөс олгосон хөрөнгийн зарцуулалтаар илэрсэн төлбөр зөрчлийн жагсаалт

(мянган төгрөгөөр)

№	Аймаг, сум болон байгууллагын нэр	Төлбөр, зөрчлийн утга	Акт, албан шаардлагын дугаар	Төлбөр зөрчлийн дүн	Үүнээс	
					төлбөр	зөрчил
1	Говь-Алтай аймгийн Засаг дарга	Баян-Уул, Эрдэнэ суманд автомашин худалдан авсан	1	30000,0		30000,0
2	Баянхонгор аймгийн ХХААЖДҮГ	Тэжээлийн буудайн тээврийн хөлсөнд илүү олгосон мөнгийг төлүүлэх тухай	1	20000,0	20000,0	
		Малчдад олгоогүй эмийг тайланд орлого авах	1	2783,3		2783,3
		Мал эмнэлгийн үйлчилгээ эрхэлдэг аж ахуйн нэгжүүдээр эм биобэлдмэлийг орлого авахуулж, зарцуулалтын тайланг гаргуулах	2	9107,2		9107,2
3	Ховд аймгийн Үенч сумын Засаг дарга	Зориулалт бусаар зарцуулсан мөнгийг төлүүлэх тухай	1\86	10000,0	10000,0	
	Ховд сумын Засаг дарга	Үлдэгдэл мөнгө төвлөрүүлэх	2\87	2100,0	2100,0	
	Ховд аймгийн Засаг даргын тамгын газар	Хөрөнгийг бүртгэлд авах	1\34	28600,0		28600,0
4	Өвөрхангай аймгийн Засаг дарга	ОХУ-аас хүмүүнлэгийн тусламжаар ирсэн улаан буудайн тээврийн зардалд зарцуулсан	3	47512,0		47512,0
		Гурил бэлтгэхдээ тухайн үеийн зах зээлийн ханшаас өндөр үнээр бэлтгэсэн	4	3063		3063
		Малчдад үнэгүй олгох эмийг худалдан борлуулсан	5	600,0		600,0
	Өвөрхангай аймгийн ОБХ	Автомашин сэлбэгт зарцуулсан	1	2000,0		2000,0
	Өвөрхангай аймгийн ХХААЖДҮГ	Малчдад олгох зориулалттай нүүрсийг үндсэн баримтгүй олгосон	2	2900,0		2900,0
5	Дундговь аймгийн ХХААЖДҮГ	Малчдаас бэлэн мөнгө хурааж тээврийн хөлсөнд зарцуулсан	1	440,0	440,0	
6	Завхан аймгийн ОБХ	Автомашин сэлбэгт зарцуулсан	1	5653,0	5653,0	
	Завхан аймгийн улсын нөөцийн газар	Хувь хүний орлогын албан татвар суутгаагүй	2	100,0	100,0	
	Завхан аймгийн Улиастай сумын Засаг дарга	Тусламжаар олгох барааг зориулалтын дагуу зарцуулаагүй	3	577,5	577,5	
		Тусламжийн мөнгөнөөс нэгдүгээр сард худалдан авсан нүүрсний үнийг шилжүүлсэн	4	727,2	727,2	
	Отгон сумын Засаг дарга	УБ хотоос таримал ургамлын үр болон тракторын чиргүүл агрегат ачиж ирсэн тээврийн зардлыг төлсөн	5	1500,0	1500,0	
	Завханмандал сумын Засаг дарга	Тусламжийн мөнгөнөөс гуравдугаар сард худалдан авсан нүүрсний үнийг шилжүүлсэн	6	1235,0	1235,0	
	Их-Уул сумын Засаг дарга	Зориулалт бусаар зарцуулсан мөнгийг төлүүлэх тухай	7	1470,0	1470,0	
НИЙТ ДҮН				170368,2	43802,7	126565,5



МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙ АУДИТОРЫН ТУШААЛ

2010 оны 10 сарын 21 өдөр

Дугаар 97

Улаанбаатар хот

Аудитын тайланг баталгаажуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 13.4.5, "Гүйцэтгэлийн шалгалтын журам"-ын 23 дугаар зүйлийн 2, "Гүйцэтгэлийн аудитын тайланг хянан баталгаажуулах журам"-ын 4.2-т заасныг тус тус үндэслэн ТУШААХ нь:

Нэг. "2010 онд өвөлжилт онц хүндэрсэн аймгуудад улсын төсвөөс олгосон хөрөнгийн зарцуулалт, хэрэгжилт, үр дүн"-д хийсэн гүйцэтгэлийн аудитын тайланг баталсугай.

Хоёр. Аудитын тайланг Улсын Их Хурлын Төсвийн Байнгын хорооны дарга Ц.Даваасүрэн, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд Т.Бадамжунай, холбогдох аймгийн Засаг дарга нарт хүргүүлсүгэй.

Гурав. Аудитын тайлангаар өгөгдсөн зөвлөмжийг хэрэгжүүлэх арга хэмжээ авч, дүнг 2011 оны 02 дугаар сарын 15-ны дотор Үндэсний аудитын газарт танилцуулахыг Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд Т.Бадамжунайд зөвлөсүгэй.

Дөрөв. Аудитын тайланд тусгагдсан зөвлөмжийн хэрэгжилтэд хяналт тавьж, үр дүнг тооцож ажиллахыг Гүйцэтгэлийн аудитын газрын захирал Д.Ганбилэгт даалгасугай.

МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙ АУДИТОР



Ч.РАДНАА

073204